

ГОВЬСҮМБЭР АЙМАГТ 2020 ОНД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2021.01.06

Сүмбэр сум

НЭГ: БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Говьсүмбэр аймаг дахь Цагдаагийн хэлтэст иргэд, хуулийн этгээдээс 889 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 323 буюу 36.3 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 566 буюу 63.7 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл урд оны мөн үеэс мэдээлэл 53-аар буюу 19.6 хувиар өсч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 35-аар буюу 6.5 хувиар, нийт хүлээн авсан гомдол мэдээлэл 88-аар буюу 18 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 889 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 882 буюу 99.2 хувийг нь шийдвэрлэсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй 323 гомдол хүлээн авснаас 317 буюу 98.1 хувийг шийдвэрлэж 6 гомдлын үлдэгдэлтэй байна. Шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:

-Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн – 191 буюу 60.3 хувь

-Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан – 126 буюу 39.7 хувь байна.

Гомдол мэдээллийн 215 буюу 67.8 хувийг 5 хоногт, 6-19 хоногт 102 буюу 32.2 хувийг шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн шинжтэй нийт 566 гомдол мэдээллийг хүлээн авч шалгаснаас 565 буюу 99.8 хувийг нь шийдвэрлэж 1 гомдлын үлдэгдэлтэй байна. Шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:

-Зөрчлийн хэрэг нээсэн-198 буюу 35 хувь

-Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан-95 буюу 16.8 хувь

-Хялбаршуулсан журмаар шийдсэн-267 буюу 47.2 хувь

-Харъяалалын дагуу шилжүүлсэн-5 буюу 0.8 хувь байна.

-Үлдэгдэл-1 буюу 0.2 хувь

Гомдол мэдээллийн 561 буюу 99.3 хувийг 5 хоногийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

/Гомдол мэдээлэл графикаар/



/Гэмт хэрэг графикаар/



Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг

Говьсүмбэр аймагт 2020 онд 148 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6-аар буюу 3.9 хувиар буурсан.

Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг /сумдаар/

№	Сум	2019 он	2020 он	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Баянтал сум	16	14	2	-12.5
2	Сүмбэр сум	122	115	7	- 5.7
3	Шивээговь сум	16	19	3	18.8

Бүртгэгдсэн гэмт хэрэг /хэргийн ангиллаар/


Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

- хүнд гэмт хэрэг 17 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 3-аар буюу 15 хувиар
- хөнгөн гэмт хэрэг 131 бүртгэгдсэн нь 3-аар буюу 2.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Гэмт хэргийн илрүүлэлт:

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2020 онд хэрэг бүртгэлтийн /эзэн холбогдогч нь тогтоогдоогүй/ 129 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 77 хэргийн яллагдагчаар татагдвал зохих этгээдийг олж илрүүлсэн. Гэмт хэргийн илрүүлэлт 59.7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар өссөн.


Бүртгэгдсэн тодорхой төрлийн гэмт хэрэг /Хэргийн өнгөөр/





Хэргийн өсөлт бууралтыг өнгөөр харуулбал:




Хэргийн өсөлт, бууралтыг өнгөөр харуулбал:



Гэмт хэрэг үйлдэгдсэн цаг, гарагаар




Гэмт хэрэг үйлдэгдсэн газар



Гэмт хэргийн хохирогч, хохирол

Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 82 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал нас барсан хүн 1 буюу 16.7 хувиар, гэмтсэн хүн 1-ээр буюу 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Иргэн, хуулийн этгээдэд учирсан 3585.9 сая төгрөгийн хохирлын 160.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлжсэн 9.2 сая төгрөгийн хөрөнгө битүүжилжээ.



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 24 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 3-аар буюу 14.3 хувиар эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 1-ээр буюу 5.9 хувиар, бүлгээр үйлдсэн гэмт хэрэг 18 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 1 дахин тус тус өсч, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 54 бүртгэгдсэн нь урд оны мөн үеэс 9-өөр буюу 14.3 хувиар буурч, хүүхэд оролцсон гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь урд оны мөн үеийн түвшинд байна.

Бүртгэгдсэн зөрчлийн талаар:

Нийт 20232 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4537 буюу 18.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт 19919 иргэнийг 644387.2 төгрөгөөр

торгож 112 иргэнийг баривчлуулж, 182 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасчээ.

Зөрчил үйлдэгдсэн өдрөөр харуулбал: Даваа гарагт 3153, мягмар гарагт 2907, лхагва гарагт 3138, пүрэв гарагт 3000, баасан гарагт 2997, бямба гарагт 2370, ням гарагт 2667 зөрчил бүртгэгдсэнээс даваа, лхагва, пүрэв, баасан гарагуудад дийлэнх зөрчил үйлдэгдсэн байна.

Зөрчил үйлдэгдсэн газар, цаг хугацаа: Өглөөний 06-12 цагийн үед 4419, 13-18 цагийн үед 9059, 19-24 цагийн үед 5804, 01-05 цагийн үед 950 зөрчил тус тус бүртгэгдсэн байна. Үүнээс үзэхэд 13-18 цагийн үед дийлэнх зөрчил үйлдэгдэж байна.

Зөрчил үйлдэгдсэн газраар нь авч үзвэл: Гэр орон сууцанд 87, олон нийтийн газар-11, гудамж талбайд 38, аж ахуйн нэгжид-7, төрийн байгууллага 5, авто замд 324, бусад газар 12 зөрчил үйлдэгджээ. Гэр орон сууц, авто замд дийлэнх зөрчил үйлдэгджээ.

Зөрчил үйлдэгдсэн онцлогоор нь: Согтуугаар үйлдсэн-350, эмэгтэй хүн оролцсон-75, хүүхэд оролцсон-2, гадаадын иргэн-0, бүлэглэн-3 гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил-31 тус тус бүртгэгдсэн.

Эрүүлжүүлсэн шалтгаанаар ангилбал: Энэ онд нийт 702 хүнийг эрүүлжүүлсэн нь урд оны мөн үеэс 187-оор буюу 21 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэсэн үедээ бусдын амгалан тайван байдал алдагдуулсан-69, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ хаана байгаагаа мэдэхгүй ухаангүй болсон-11, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож гэмт хэрэг, зөрчилд холбогдсон-95, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчилд холбогдсон-120, гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 395, гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийн улмаас 12 хүнийг эрүүлжүүлсэн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. Гэмт хэрэг урд оны мөн үеэс 148-аар буюу 3.9 хувиар буурсан нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээ, эргүүл, постуудыг оновчтой цаг хугацаанд үр дүнтэй арга хэлбэрээр зохион байгуулсантай холбоотой байна.

2. Хэргийн илрүүлэлт урд оны мөн үеэс 1.4 хувиар өссөн нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий тасаг, хэсгийн хамтын үйл ажиллагаа, ажлын зөв бодлого, зохион байгуулалттай холбоотой байна.

3. Коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд согтууруулах ундааны зүйл худалдах, үйлчлэхийг хориглож цагийн хуваарийг богинсгосон, хорио цээрийн дэглэм сахиулах эргүүл, хяналт шалгалтын постуудыг үр дүнтэй зохион байгуулах ажлыг тухай бүр авч хэрэгжүүлснээр согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 14.3 хувиар, гэмт хэрэг, зөрчлийн гаралт 3.9-18.3 хувиар, эрүүлжүүлэгдсэн хүн 21 хувиар, баривчлагдсан хүн 14.5 хувиар, гудамж талбай олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 12.5 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлт байна.

4. Нийт гэмт хэргийн 43.2 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 36.4 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 7.4 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, нийт зөрчлийн 92.6 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм зөрчсөн зөрчлүүд бүртгэгдсэн байна.

5. Энэ онд сүүлийн 5 жилд бүртгэгдэж байгаагүй цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдсэн нь онцлог байна.

ТАВ: САНАЛ

1. Цаашид шинэ төрлийн гэмт хэрэг болох цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэргийг бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой үр дүнтэй зохион байгуулах, залилах гэмт хэрэг нь ихэвчлэн сошиал медиа нийгмийн сүлжээг ашиглан үйлдэгдэж байх тул алба

хаагчдыг энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажилд чадавхжуулах

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд шинэлэг техник технологийг нэвтрүүлэх, цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон нийгмийн сүлжээгээр тасралтгүй зохион байгуулах

3. Шивээговь сумын Цагдаагийн хэсэг 2021 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зэрэг болно.

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ХЭЛТЭС